

3

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ШАРЫН ГОЛ СУМ
“БАЯЛАГ ШАРЫН ГОЛ”
ХУВЬЦААТ КОМПАНИ**

213805 Шарыг гол, Дархан-Уул аймаг

Утас: Факс: 017343

2015.04.24 № 52.

танай _____ -ны № _____ -т

Үйл ажиллагааны тайлан

Манай компани нь 1971 онд байгуулагдсан ойд арчилгаа цэвэрлэгээ хийх, Ойжуулалт, ойг нөхөн сэргээх, мод үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулаж байсан мод бэлтгэлийн аж ахуйг 2002 онд худалдана авч мод модон материал боловсруулж орон нутгийн аж ахуй нэгж, иргэд, бусад аймаг сумдыг модон материалаар хангаж үйл ажиллагаагаа өргөтгөн ажилсаар ирсэн. Манайх сумынхаа 51 иргэнийг түр болон бүр ажлын байраар хангаж байгаад, 2013 оноос мод бэлтгэлийн хувиар 100 м3 хувиарлагдаж, зарим ажилчдаа ажлаас нь чөлөөлж, хуучин ажилчидаасаа 30 хүн авч ажилсан. 2014 онд ойжуулалт болон мод бэлтгэлээр түр 24 хүн ажилуулсан.

Нэг. Мод бэлтгэлийн ажлын талаар:

2014 оны мод бэлтгэл 100 м3 Хуурай хэрэглээ ажлыг 11 сарын 25 нд Шарын гол сумтай гэрээ хийж нийт 8 хүний бүрэлдхүүнтэй 11.27 нд ажилдаа гарч 12.24 нд ажлаа дуусгасан. Энэ хугацаанд 55-тракторт эвдрэл их гарсан.

Хоёр . Зүүмэл хавтангийн Цехын ажлын талаар

2006 онд 20 м3 хатаалгын камер БНХАУ-аас оруулж ирж, зүүмэл хавтан хийх тоног төхөөрөмж авч Зүүмэл хавтангийн цех ажилуулж эхэлсэн. Хавтангийн хэмжээ урт нь 3метр, өргөн 1м, 4.0 мм, 3.5мм, 2.5мм, 1.8мм, 1.5мм, 1.0мм –ээр гардаг. Бид модыг хаягдал гаргахгүй ашиглахын тулд хавтангийн өнгийг төрөл бүрээр нь ялгадаг. Жишээ нь: Цэвэр, давирхай, их давирхай, хөхтэй, яртай, холтостой, судалтай, ягаантай, бортой, нэг тал нь цэвэр гэх мэт. Зах банзаа зарахгүй хашаандаа хурааж байгаад цэвэр банзгүй болохоороо хатаалганд хийж хатаагаад гадна, дотор рейк хийдэг. Рейкний хэмжээ янз бүр урт нь 4, 1.5, 2 гэх мэт захиалсан хэмжээгээр гарна. Гадна, дотор рейкээр байшин, саун, албан байгууллага хаус гэх мэт бүх л хэрэгцээнд хэрэглэнэ. .

Энэ бэлдэцээ Улаан баатар хотод байрлах *Интер стиль*ХХК-тавилгын үйлдвэрт нийлүүлдэг. Мөн сум орон нутгийн иргэд хавтанг захиалж хийлгүүлдэг. 2012 онд 40 м3 хатаалгын камер авсан боловч, 2013 онд модны хувиар багасаж

Хүдрээс палк авч зүсэж зүүмэл хавтан хийсэн. 2014 онд нойтон модны эрх өгөөгүй болохоор зүймэл хавтангын цехийг ажилуулаагүй .

Хоёр. Ойжуулалтын ажлын талаар

2014 онд Дархан-Уул аймгийн Байгаль орчин газарт тендерийн шалгаруулалтанд оролцож Мойл ууланд 30 га ойжуулалтын ажлыг авч 16 хүний бүрэлдхүүнтэй ажлыг хийж гүйцэтгэсэн, хүлээлгэж өгсөн. Хүлэмжнээсээ 2 настай нарсyг хураан авч ойжуулалтанд ашигласан.

Дөрөв. Бусад ажлын талаар :

- 1. 2014 онд 17*1.20 хэмжээтэй 2 хүлэмж нэмж УБ-хотын үрийн лабортоороос нарсны үр худалдан авч үрслүүлсэн.
- 2. Жил бүрийн хавар, намрын хуурайшилтын үед ой хээрийн түймрийн эргүүлд долоон хоногоор 2 удаа гардаг.
- 3. Байгууллагадаа удаан ажилсан, болон хуучин ажиллаж байсан ажилчиддаа галын түлээ үнэгүй болон хөнгөлттэй үнээр өгсөн.
- 4. Хүүхдийн баяр болон, шинэ жилээр ажиллаж байгаа ажилчидынхаа хүүхдүүдэд бэлэг өгсөн.
- 5. *Домогт шарын гол* ХХК-д 20 м.күб 5-н банз хатааж өгөв.
- 6. Ажилчидаа сургалтанд хамруулж мэргэжлийн үнэмлэхтэй болгов.

Тайлан бичсэн *Б. Энхцэцэг* Б.Энхцэцэг.

